



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн загвар шинэчлэн батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.18 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1.Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийн үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг хоёрдугаар, хөтөлбөрийн тайлан бичих зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг жил бүр үнэлж тайланг Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хөгжлийн хэлтэст ирүүлж байхыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр), Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

D:\Standart\tushaal.docx

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 сарын 21-ний өдрийн 437 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын
тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн
хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН / байгууллагын нэр / ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**

Батламжийн дугаар:	... / ...
Магадлан итгэмжлэгдсэн хугацаа:	... жил
Хөтөлбөр хэрэгжүүлж эхлэх хугацаа:	... он ... сар ... өдөр
Хөтөлбөр хэрэгжүүлж дуусах хугацаа:	... он ... сар ... өдөр
Хөтөлбөр ирүүлсэн хугацаа:	... он ... сар ... өдөр
Хөтөлбөр баталсан хугацаа:	... он ... сар ... өдөр
Хөтөлбөрийг хянасан мэргэжилтэн:

**Эрүүл мэндийн байгууллагын тусламж
үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр**

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Хоёр. Хөтөлбөрийн зорилтууд

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, шаардагдах нөөц /Ажлын хүснэгт/

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх он				Шалгуур үзүүлэлт		Гарах үр дүн	Хариуцах нэгж/албан тушаалтан	Шаардагдах нөөц /санхүүжилт/
		Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үеийн түвшин	Хүрэх түвшин			
1-р зорилтын хүрээнд:										
	Үйл ажиллагаа 1									
	Үйл ажиллагаа 2									
	Үйл ажиллагаа 3									
2-р зорилтын хүрээнд:										
	Үйл ажиллагаа 1									
	Үйл ажиллагаа 2									
	Үйл ажиллагаа 3									
3-р зорилтын хүрээнд:										
	Үйл ажиллагаа 1									
	Үйл ажиллагаа 2									
	Үйл ажиллагаа 3									

Тав. Хяналт- шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

5.1 Дотоодын хяналт- шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

№	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны чиглэл	Хугацаа /сар, улирал, хагас жилээр/	Хариуцах албан тушаалтан
1			
2			
3			

**Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг
үнэлэх араах шалгуур үзүүлэлтүүд**

№	Шалгуур үзүүлэлтүүд	Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн он	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа		
		2013 он	... он	... он	... он
1.	Тухайн жилийн чанарын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь				
2.	Тусламж үйлчилгээнд хэрэгжүүлсэн шинэ стандарт, эмнэлзүйн удирдамжийн тоо, хэрэгжилтийн хувь				
3.	Тусламж, үйлчилгээний чанарын талаар зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан ажилтны тоо				
4.	Тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн чанар сайжруулах арга хэрэгслийн тоо				
5.	Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хувь				
6.	Чанарын урамшууллын төрөл, урамшуулал олгосон хүний тоо				
7.	Мэдээллийн санд бүртгэсэн алдааны тоо, төрөл				
8.	Тусламж үйлчилгээний нотлогдсон гомдлын тоо				
9.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь				
10.	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дотоодын хяналтын тоо				
11.	Дотоодын хяналтын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь				

5.2 Хөндлөнгийн хяналт- шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

№	Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлбэр	Хугацаа	Хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага
1	Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх	Жил бүрийн 12 сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо
2	Хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийх	Магадлан итгэмжлэлийн хугацаанд	ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар
3	Магадлан итгэмжлэлийн төгсгөлийн үнэлгээ	Хугацааны эцэст	ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар /магадлан итгэмжлэлийн шинжээчид/

Зургаа. Хөтөлбөрийн баталгаажилт:

- Тухайн эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга,
- Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга нар баталгаажуулна.

/ гарын үсэг,тамга /

... он ... сар ... өдөр

Хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх аргачлал

Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 237 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын 6.4 дэх заалтын дагуу “Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр” /цаашид чанарын хөгжлийн хөтөлбөр гэх/ боловсруулж хэрэгжүүлнэ.

Чанарын хөгжлийн хөтөлбөр нь тухайн байгууллагын дахин магадлан итгэмжлүүлэх үндсэн үзүүлэлт болно.

Чанарын хөгжлийн хөтөлбөр нь тухайн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийг хангах, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад чиглэгдсэн байх ба эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл, бодлого, байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж, үзүүлж буй тусламж үйлчилгээний чиглэл, өвөрмөц онцлогт тохируулан боловсрогдсон байна.

1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээний чанарын бодлого, байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж, хөтөлбөр хэрэгжиж дуусахад хүрэх түвшинг тодорхойлсон байна.

2. Хөтөлбөрийн зорилт

Зорилт нь хөтөлбөрийн зорилгыг бүхэлд нь хангахад чиглэсэн, өөр хоорондоо уялдаатай шинж чанараараа ялгаатай алхамууд бөгөөд одоогийн хүрсэн амжилтаа бататгах, сайжруулахад чиглэгдэнэ.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Эрүүл мэндийн байгууллага нь чанарын хөгжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэгдсэн хугацаанд хэрэгжүүлнэ.

4. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, шаардагдах нөөц

Хөтөлбөрийг боловсруулахдаа ажлын хүснэгтийг ашиглаж хөтөлбөрийн зорилго, зорилт бүрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлт, гарах үр дүн, хариуцах нэгж /албан тушаалтан, шаардагдах нөөцийг тус тусад нь тодорхойлно. Мөн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн өгсөн зөвлөмжид тусгасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Хөтөлбөрийн зорилт бүрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааг байгууллагынхаа тухайн жилийн болон чанарын албаны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт дараах үйл ажиллагаануудыг заавал хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:
 1. Тусламж үйлчилгээний чанарын сургалт /жилд 2-оос доошгүй удаа/ зохион байгуулах;
 2. Чанар сайжруулах шинэ арга хэрэгсэл /жил бүр 1-ээс доошгүй/-ийг нэвтрүүлж, үр дүнг тооцох;
 3. Чанарын урамшууллын тогтолцоо бий болгох;
 4. Шинээр батлагдсан стандарт, удирдамжаар хангах, сургалт зохион байгуулах, мөрдөж ажиллах;
 5. Тусламж үйлчилгээнд сэтгэлд нийцсэн 8 үйлчилгээ (угтах, лавлах, эргэх, зөвлөх, оношлох, эмчлэх сувилах, хөнгөвчлөх) тус бүрээр үйл ажиллагаа явуулах, үр дүнг тооцох;
 6. Тусламж үйлчилгээ үзүүлэхэд тохиолдох эрсдлийг тодорхойлж, түүнд тулгуурлан эрсдлийг бууруулах, эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх;
 7. Алдаа, зөрчлийг бүртгэж, мэдээллийн сан үүсгэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах,
 8. Өөрийн байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, мөрдөх.
- Үйл ажиллагаа бүрийн хийх хугацааг тодорхой бичнэ.
- Шалгуур үзүүлэлтийг хөтөлбөр хэрэгжиж эхлэх үеийн түвшин /өнөөгийн түвшин/, хөтөлбөр хэрэгжиж дуусах үеийн түвшин /хүрэх түвшин/-гээр тоон ба чанарын үзүүлэлтийг ашиглан тодорхойлно.
- Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр гарах үр дүнг бичнэ.
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтныг тодорхой зааж өгнө.
- Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, нөөцийг тодорхойлно. Үүнд: өөрийн байгууллагын төсөв, дотоод нөөц, хөтөлбөр, төсөл, олон улсын байгууллагын хандив гэх мэт багтана.

Хөтөлбөрийг боловсруулахдаа А4 хэмжээтэй цаасан дээр Arial үсгийн фондоор үсгийн өндөр 12-оор бичих ба хэвтээ хэлбэртэй байна. Хөтөлбөрийг 2 хувь бичиж баталгаажуулах ба баталгаажуулсан хөтөлбөрийн нэг хувь ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт, нэг хувь нь тухайн байгууллагад байна.

Тав. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрт дотоодын ба хөндлөнгийн хяналт- шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Эрүүл мэндийн байгууллага нь дотоодын хяналт- шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, хяналт- шинжилгээ, үнэлгээг хийх үйл ажиллагааны чиглэл, хугацаа, хариуцах алба /баг/, ажилтныг тодорхойлсон байна.

Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь явцын ба төгсгөлийн үнэлгээ гэсэн 2 үе шаттай хийгдэнэ.

Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо хийж гүйцэтгэнэ.

Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр үнэлнэ. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй үйл ажиллагааны биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- Тухайн жилд тавьсан зорилт, үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн, үр дүн нь гарсан бол 100 хувь;
- Тухайн жилд тавьсан зорилтод бүрэн хүрээгүй боловч үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, үр дүн гарч эхэлж байгаа бол 90 хувь;
- Тухайн жилд тавьсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өөрсдөөс хамаарах бүх арга хэмжээ авагдсан, хөрөнгө санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн бол 80 хувь;
- Үйл ажиллагааны бэлтгэл ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд хийгдэж байгаа бол ажлын түвшинг харгалзан 70 -60 хувь;
- Тухайн үйл ажиллагааг хийх бэлтгэл ажил хийгдэж дуусаад, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол ажлын түвшинг харгалзан 50-40 хувь;
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар бэлтгэл ажил хийгдэж эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 30 -20 хувь;
- Бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол 10 хувь
- Ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 үнэлгээ өгнө.

Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлтүүд	Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн он	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа		
			... он	... он	... он
12.	Тухайн жилийн чанарын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь				
13.	Тусламж үйлчилгээнд хэрэгжүүлсэн шинэ стандарт, эмнэлзүйн				

	удирдамжийн тоо, хэрэгжилтийн хувь				
14.	Тусламж, үйлчилгээний чанарын талаар зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан ажилтны тоо				
15.	Тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн чанар сайжруулах арга хэрэгслийн тоо				
16.	Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хувь				
17.	Чанарын урамшууллын төрөл, урамшуулал олгосон хүний тоо				
18.	Мэдээллийн санд бүртгэсэн алдааны тоо, төрөл				
19.	Тусламж үйлчилгээний нотлогдсон гомдлын тоо				
20.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь				
21.	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дотоодын хяналтын тоо				
22.	Дотоодын хяналтын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь				

Чанарын хөгжлийн хөтөлбөрийн тайлан бичих заавар

Эрүүл мэндийн байгууллага нь чанарын хөгжлийн хөтөлбөрийн тайланг тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрээр гарсан өөрчлөлт, шинэчлэл, ахиц дэвшил, ололт амжилтыг бодит баримт бичиг, статистик үзүүлэлтүүдэд тулгуурлан үндэслэл сайтай, өмнөх үетэй харьцуулан үнэлж, дүгнэж бичнэ.

Эрүүл мэндийн байгууллага нь хөтөлбөрийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн харъяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар (ЭМГ), Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо (ХХЭМБНХ) -д тус тус хүргүүлэх ба аймаг, нийслэлийн ЭМГ, ХХЭМБНХ холбоо нь хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх аргачлалын дагуу байгууллага тус бүрийн тайланд үнэлгээ хийж, эрүүл мэндийн байгууллагын давуу, сул талыг дүгнэж, нэгдсэн тайлангийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт (ТЗУГ)-т ирүүлнэ.

Эрүүл мэндийн яамны харъяа байгууллагууд хөтөлбөрийн тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор ЭМСЯ-ны ТЗУГ-т ирүүлнэ.

ЭМСЯ-ны ТЗУГ нь жил бүрийн 01 дүгээр сарын 25-ны дотор ЭМСЯ-ны харъяа байгууллагууд, аймаг, нийслэлийн ЭМГ, ХХЭМБНХ-оос ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлэх ба тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулна.

Эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэлийн хугацааны эцэст тусламж үйлчилгээний чанарт гарсан ахиц дэвшлийг тусгасан “Төгсгөлийн тайлан” бичнэ.

Тайланг цаасан болон цахим хэлбэрээр ирүүлнэ. Цаасаар ирүүлэх тайланг А4 хэмжээтэй цаасан дээр Arial үсгийн фондоор үсгийн өндөр 12-оор бичнэ. Тайланд холбогдох материалыг хавсарган ирүүлж болно.